

Хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэж буй гадаад, дотоодын туршлага, цаашдын чиг хандлага

Төмөртогтохын Дэлгэрсайхан

Магистр, ахлах судлаач, delgersaikandisa@gmail.com

Монгол Улс, Улаанбаатар, Цагдаагийн ерөнхий газрын

Стратеги, бодлого, инновац, хөгжлийн алба

Хураангуй

Хар тамхины хууль бус эргэлт нь өнөөгийн дэлхий нийтийн өмнө тулгамдсан ноцтой аюул занал болж, улс орнуудын нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжилд үлэмж хэмжээний сөрөг нөлөө үзүүлж байна. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэхэд олон улсын болон Монгол Улсын хэмжээнд хуримтлагдсан туршлага, ололт амжилтыг нэгтгэн дүгнэж, цаашдын үр дүнтэй бодлогын чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон юм.

Судалгаанд хар тамхины хууль бус эргэлтийн улмаас үүсэж буй сөрөг үр дагаврууд, мөн түүнтэй тэмцэх эрх зүйн орчин, хэрэгжилтийн асуудлыг дүн шинжилгээ хийсэн. Ялангуяа, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эмчлэх, нөхөн сэргээх зэрэг цогц арга хэмжээний үр нөлөөг олон улсын жишиг болон Монголын нөхцөл байдалтай харьцуулан судалсан болно. Мөн гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгарч буй бэрхшээл, сорилтууд, тухайлбал, технологийн дэвшил, гэмт хэргийн зохион байгуулалттай шинж чанар зэргийг хөндлөө. Судалгааны үр дүнд үндэслэн хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэхэд чиглэсэн иж бүрэн стратеги, хамтын ажиллагааны шинэ чиг хандлагыг санал болгосон нь энэхүү нийтлэлийн гол хувь нэмэр юм.

Түлхүүр үг: Хар тамхи, нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх, олон улсын хамтын ажиллагаа, хилийн хяналт

Нэг. Эрх зүйн зохицуулалт

Монгол Улс 2003, 2008 онд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гол конвенцэд нэгдэн орсноор гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх болон дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүрэг хүлээсэн. Тухайлбал: 1961 оны “Мансууруулах бодисын тухай Нэгдсэн конвенц”, 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц”, 1988 оны “Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”-д мансууруулах бодисын хууль бус үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээ, хадгалалтыг гэмт хэрэгт тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хууль ёсны хэрэглээнд хяналт тогтоох, тайлагнах үүрэг хүлээсэн юм. Мөн мансууруулах бодисын жагсаалтыг шинэчилж, гадаад улсуудтай хамтран мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцод нэгдсэнээр хар тамхины хил дамнасан гэмт хэрэгт холбогдох этгээдийг олж тогтоох, шилжүүлэн өгөх, баривчлах, нотлох баримт цуглуулах зэрэг хууль сахиулах байгууллагуудын хамтын болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг улс хооронд хэрэгжүүлж байна. Ийнхүү Монгол Улс эдгээр олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орсноор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, түүнтэй холбоотой зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд олон улсын өмнө үүрэг бүхий оролцогч тал болсон байна (Гадаад харилцааны яам, 2018).

Монгол Улс 2002 онд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг батлан хэрэгжүүлснээр мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль ёсны эргэлтэд хяналт тавих, тэдгээрийг эмчилгээ, судалгааны зориулалтаар зөвшөөрөлтэй ашиглах, хууль бус наймаа, хэрэглээг үе шаттай таслан зогсоох үндэс суурийг бүрдүүлсэн юм.

Хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд 2002 оны Эрүүгийн хуульд анх удаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт тусгайлан хариуцлага хүлээлгэх заалтуудыг тусгасан. Үүнд тухайн бодисыг хууль бусаар олж авах, тарих, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, худалдах, бусдад дамжуулах, түүнчлэн хэрэглэгчийг орон байр, хэрэглэх нөхцөлөөр хангах зэрэг үйлдэл багтжээ.

Эрүүгийн хуулийн 2015 оны шинэчилсэн найруулгад дээрх заалтуудыг илүү нарийвчлан тусгаж, ял оногдуулах үндэслэл, хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн тодорхой болгосон. Түүнчлэн зохион байгуулалттай бүлэглэлээр хил дамнасан, бусдын эрүүл мэндэд хор учруулахуйц хэмжээний бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан тохиолдолд хатуу шийтгэл ногдуулах хуулийн зохицуулалттай болсон.

Ийнхүү үндэсний хууль тогтоомжоо олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн шинэчилж, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн тогтолцоогоо үе шаттайгаар боловсронгуй болгосон нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чухал суурь нөхцөлийг бүрдүүлжээ.

Монгол Улсын Их Хурал 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг 18 зүйлтэйгээр анх баталсан. Өнгөрсөн 21 жилийн хугацаанд уг хуульд нийт долоон удаагийн нэмэлт, өөрчлөлт (2011, 2011, 2015, 2021, 2022, 2022, 2023) орсон байна. Уг хуулийн хэрэгжилт, зохицуулалт, практик дахь үр дагаврыг цэгцлэх шаардлага байгааг 2021 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгасан. Тус баримт бичгийн 63 дугаарт зааснаар Хууль зүй, дотоод хэргийн яам Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар үүрэг хүлээсэн. Энэхүү шинэчилсэн найруулгын хүрээнд мансууруулах болон тэдгээрийн

угтвар бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, Эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлэх, Мансууруулах бодист донтсон иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлүүдийг тусгах шаардлага тавигдсан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн наймдугаар зүйлийн 8.1.1-д хууль санаачлагчид тухайн харилцааг зохицуулж буй хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлсний дараа л шинэ төсөл боловсруулна гэж заасан боловч өнөөг хүртэл “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаврын талаарх албан ёсны судалгаа, үнэлгээ хийгдээгүй нь хууль эрх зүйн шинэчлэл, шинэ найруулгын үндэс, суурь мэдээлэл дутагдалтай байгааг харуулж байна (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол, 2016).

Монгол Улсад “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийг 2018 онд шинэчлэн найруулсан. Уг хуулийн гол зорилго нь өөртөө болон бусдад аюул учруулахуйц эрсдэлтэй байдалд хүрсэн, эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр мансуурах донтой болох нь тогтоогдсон ч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзаж буй иргэнийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх агуулгатай юм.

Хуулийн хүрээнд албадан эмчилгээг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт явуулах, эмнэлэг нь шүүхийн шийдвэрийг үндэслэн нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр иргэнийг хүлээн авах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хууль, журам, стандартын дагуу үзүүлэх, уг эмнэлэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд ажиллахаар заасан. Гэвч дээрх заалт бодит байдалд хэрэгждэггүй бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох алба нэгжүүдэд мансууруулах бодисын донтой хүнийг албадан эмчлэх чиг үүргийг хэрэгжүүлдэггүй, ийм төрлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг тухайн байгууллагын бүтцэд байхгүй байна. Нөгөө талаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд зөвхөн сайн дурын үндсэн дээр сэтгэл заслын болон нөхөн сэргээх эмчилгээ хийж байна. Ийнхүү хуульд заасан албадан эмчлэх тогтолцоо хууль зүйн үндэслэлтэй боловч хэрэгжилт нь эзэнгүй, бүтэцгүй, зохион байгуулалтгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт ба практик бодит байдал хоорондын зөрүүг тод харуулж байна.

Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарын судалгаа, нэгдсэн тоо баримт байхгүй нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хаана, хэзээ оновчтой зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө гаргахад хүндрэлтэй байна. Тухайлбал: Эрүүл мэндийн яам болон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2024 онд хийсэн судалгааны хүрээнд Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол, архи болон мансууруулах бодисын хэрэглээтэй иргэд, донтогчдын мэдээллийг бүртгэх нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх журмыг боловсруулсан. Уг журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн сайд нар хамтран батлахаар төлөвлөсөн боловч одоогоор албан ёсоор батлагдаагүй байна (Судалгааны тайлан, 2024, р. 8).

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд хийсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайланд дурдсанаар Монгол Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль тогтоомж нь олон улсын гэрээний шаардлага, практик хэрэгжилттэй уялдахгүй байгаа нь эрх зүйн хийдэл, зохицуулалтын зөрчил, бүтэцгүй байдал үүсгэж байна. Ялангуяа олон улсын гэрээнд тусгасан “түгээх”, “экспортлох”, “импортлох”, “дамжуулах” зэрэг гэмт хэргийн үйлдэл нь Эрүүгийн хуульд бүрэн тусгагдаагүй бөгөөд зарим нэр томьёо хоорондын ялгаа тодорхойгүй байна. Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон улсын конвенцын зохицуулалтыг гүйцэд хуульчлахгүй байгаагаас олон улсын үүргийн хэрэгжилт сул гэж дүгнэхээр байна. Тухайлбал: Судалгаа, шинжилгээний зорилгоор мансууруулах бодис ашиглахтай холбоотой зохицуулалт, хяналтын механизм тодорхойгүй байна. Түүнчлэн хил, гаалийн байгууллагын чадавх хязгаарлагдмал, хүний нөөцийн тогтворгүй байдал, техник, технологийн хоцрогдол нь мансууруулах бодисын хууль бус нэвтрэлтэд өртөмтгий орчин бүрдүүлж байна гэж дээрх судалгаагаар дүгнэсэн.

Хууль зүйн үндэсний төвөөс хийсэн судалгаанд дурдсанаар хар тамхины хадгалалт, устгалын тухай хуулийн зохицуулалт ерөнхий түвшинд байгаа ба практикт хэрхэн хэрэгжиж буй нь тодорхой бус, устгах ажиллагаанд хяналт тавих бүтэц, журмын хэрэгжилт сул байна. Үүнээс гадна мансуурах донтой этгээдийг сайн дурын болон албадан эмчлэх зохицуулалт тодорхойгүй, хэрэгжих боломжгүй байгаа нь эмчилгээний хүртээмжийг хязгаарлаж байна. Төрийн зүгээс албадан эмчлэх байгууллага тодорхойгүй, зохион байгуулалт алга байна. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг 2009-2023 оны хооронд 23 дахин өссөн нь хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээ үр дүнгүй байгааг харуулж байна гэж дээрх судалгааны тайланд онцолжээ.

Иймд эрх зүйн зохицуулалтын түвшинд Эрүүгийн болон холбогдох хуулиудыг олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн найруулж, зөвхөн эрүүгийн хариуцлагыг чангатгах төдийгүй, холбогдох конвенцод заасан үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцох, хил, гааль дээрх хяналтыг сайжруулах, хүний нөөц, техник хэрэгслийг чадавхжуулах, устгах ажиллагааны ил тод, хариуцлагатай тогтолцоог бий болгох, албадан болон сайн дурын эмчилгээний бодлогыг хэрэгжүүлэх бүтэц, механизмыг бүрдүүлэх, салбар хоорондын уялдааг хангах нэгдсэн зохицуулалт, бүтэц бий болгох хэрэгцээ шаардлага бий болсон гэж үзэхээр байна (Хууль зүйн үндэсний төв, 2023).

Хоёр. Мансууруулах бодисын хэрэглээ, тархалт

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Максима консалтинг компаниас хүүхэд, залуучуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх ойлголт, хандлага, хэрэглээ, хэрэглээний тархалтыг ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид, 25 хүртэлх насны их, дээд сургуулийн оюутнуудын дунд хийсэн “Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч

болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх” судалгаагаар тандсан байдаг.

Дээрх судалгаагаар опиоидын төрлийн бодисууд хамгийн өргөн тархалттай байгааг тогтоосон. Тухайлбал: опиоидын хэрэглээ нь давхардсан тоогоор нийт судлагдсан хүн амын 1.6 хувийг эзэлсэн бөгөөд үүний дотор трамадолын хэрэглээ 1.0 хувь, морфины хэрэглээ 0.6 хувьтай гарсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй бодисууд байв. Харин давхардаагүй тоогоор энэ төрлийн бодисын хэрэглээ 1.2 хувьтай байсан нь бусад төрлийн мансууруулах бодисоос харьцангуй өндөр түвшинд байна гэсэн дүгнэлт хийжээ. Мөн зорилтот бүлгийн хүрээнд давтан хэрэглээ 0.6 хувьтай байгаа нь хамааралтай байдлын эрсдэл өндөр байгааг илтгэж, бусад хоёр модультай харьцуулахад дунд зэргийн түвшинд, кокаины хэрэглээ 0.7, метамфетамины хэрэглээ 0.6 хувьтай тус тус бүртгэгдсэн нь анхаарал татахуйц түвшинд байгаа үзүүлэлтүүд гэсэн дүн гарсан байна. Түүнчлэн тандалт судалгаагаар нийт зорилтот бүлгийн дунд хэрэглэж үзэхэд бэлэн байгаа нь (хэрэглэж үзсэн хэсгийг оролцуулан) каннабисын хувьд 23.0, LSD-гийн хувьд 11.6, метамфетамины хувьд 10.5, морфин болон трамадол тус бүр 10.5, кокаин 15.5, бусад бодисын хувьд 8.6-10 хувь орчим тус тус байсныг тогтоосон (Судалгааны тайлан, 2024, pp. 93-95).


Судалгаанд хамрагдсан 25 хүртэлх насны оюутнуудын дунд каннабисын хэрэглээний туршлага 14.5 хувийн тархалттай, хэрэглэж үзэхэд бэлэн гэдэг нь 36.7 хувь байсан бол бусад төрлийн бодисын хэрэглээний туршлага 5.8 хувийн тархалттай, хэрэглэж үзэхэд бэлэн хүмүүсийн хувь тус бүр 16.4 болон 15.7 хувьтай гарсан (Судалгааны тайлан, 2024, р. 97). Уг тандалтаар тухайд үед хурдацтай тархсан зарим шинэ төрлийн тухайлбал: “Мими” гэдэг бодисыг судалгаанд хамруулаагүй, гэхдээ 2020 онд хийгдсэн M4 модулийн талбайн ажлын явцад дээрх бодисын өргөн хүрээтэй хэрэглээ Улаанбаатар хотын (авто засварын газруудтай) зарим цэгт илэрсэн. Ялангуяа Өмнөговь аймгийн Цогтцэций сум болон Таван Толгой-Гашуун Сухайт чиглэлийн замын дагуух хэрэглээ өндөр байгааг онцолсон. Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд хүчтэй үйлдэлтэй бодисуудын хэрэглээ, тэр дундаа опиоид төрлийн бодис (трамадол, морфин) хамгийн өргөн тархсан бөгөөд хэрэглэгчдийн ихэнх нь найз нөхдийн хүрээлэлд байна.

Нийгмийн харилцаа, амьдралын нөхцөлийг авч үзвэл, мансууруулах бодис хэрэглэгч нарын хувьд ажил эрхлэлтийн түвшин харьцангуй өндөр, зарим нь мэргэжлийн ур чадвар шаардсан, хариуцлагатай албан тушаал хашдаг байдал ажиглагдсан. Мөн боловсролын түвшин, нийгмийн идэвх, сонирхлын цар хүрээ, амьжиргааны түвшин ч дундаж, эсвэл түүнээс дээш түвшинд байх хандлагатай байна. Мансууруулах бодисын хэрэглээний шалтгааныг авч үзэхэд, судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь сониуч зан, зүгээр л оролдож үзэх, хийх зүйлгүй байх, найзуудаа даган баясах зэргийг дурдсан бол 20 орчим хувь нь таашаал, хурц мэдрэмж авахын тулд хэрэглэж байсан хэмээн хариулжээ. Мөн 10 гаруй хувь нь гэр бүлийн асуудал, хувийн амьдралын бэрхшээлээс зугтахын тулд хэрэглэсэн байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунд каннабисын хэрэглээний талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд уг бодисын гарал үүсэл тодорхойгүй байсан ч дотоодын зэрлэг ургамлаас гаралтай байх магадлалтай гэж үзжээ. Мөн синтетик каннабиноид төрлийн бодисыг хэрэглэж үзсэн нь 0.5 хувь байгаа ч сонирхсон, хэрэглэж үзэхэд бэлэн хувь 9.6 хувьд хүрсэн байна. Метамфетамин хэрэглээ судалгаанд оролцогчдын дунд 0.6 хувьтай гарсан бол оюутны дунд 2.1, бусад залуусын дунд 2.2 хувь байгаа нь цаашид энэ төрлийн бодисын хэрэглээ өсөх өндөр магадлалтайг харуулж байна. Түүнчлэн оюутнуудын дунд LSD (2.4 хувь), MDMA буюу экстази (1.4 хувь) зэрэг синтетик сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ бүртгэгдсэн нь шинэ үеийн залуусын дунд хэрэглээний төрөлжилт, туршиж үзэх сонирхол нэмэгдэж буйг илтгэж байна (Судалгааны тайлан, 2024, р. 98).

Дээрх тандалт судалгааг улсын хэмжээнд хийсэн төдийгүй 25 хүртэлх насны залуусаас түүвэрлэж авсан гэдгээрээ өмнө нь буюу 2017 онд Монголын сурагчдын холбооноос Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан дүүрэг, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 1067 хүүхдийг хамруулснаас өргөн хүрээтэй байна. Түүнчлэн Хар тамхитай тэмцэх газрын 2025 оны “Дүн шинжилгээ”-ний тайлангаас үзвэл “Экстраполяци” тархалтын хурд тодорхойлох аргачлалаар тооцоход энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж бүртгэгдсэн нийт 5579 иргэний цаана манай улсын хэмжээнд далд хэрэглэгч 20000-25000 орчим иргэн байж болзошгүй байна. Мөн тус газраас сүүлийн гурван жилийн хугацаанд хураан авсан синтетик төрлийн мансууруулах бодисын 75.8 хувийг БНТУ-аас хууль бусаар хил нэвтрүүлсэн байна.

График 1. Хураагдсан бодисын хэмжээ




Гурав. Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал

Улсын хэмжээнд 2023-2024, 2025 оны эхний хагас жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой нийт 604 гэмт хэрэгт 532 яллагдагчийг холбогдуулан шалгасан нь 2021-2022 онтой харьцуулахад гэмт хэрэг 22.7 хувиар, яллагдагч 18.5 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм (ЦЕГ, 2025). Бүртгэгдсэн гомдол, мэдээллээс 83, хэрэг бүртгэлтийн хэргээс 480, нийт мөрдөн

байцаалтын 563 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас шүүхэд шилжүүлэх саналтай 483 хэргийг шийдвэрлэжээ.


Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 98 хувийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан, улсын хилээр нэвтрүүлсэн гэмт хэрэг эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэргийн 84.8 хувь нь нийслэлд, 15.2 хувь нь орон нутагт, үүнээс 20.0 хувь нь Баянзүрх дүүрэг, 6.0 хувь нь Дархан-Уул аймагт бүртгэгдсэн.

График 2. Бүртгэгдсэн хэрэг, яллагдагчаар татсан статистик



Нийт бүртгэгдсэн 532 яллагдагч нь насны ангиллаар 13-60 насны, дундаж үзүүлэлтээр 21-23 насны иргэд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байна.

График 3. Яллагдагчийн насны ангилал



Энэ төрлийн гэмт хэрэгт яллагдагчаар бүртгэгдсэн этгээдийн дийлэнх буюу 57 хувийг “Бүрэн дунд боловсролтой” эзэлж байгаа бол 23 хувийг “дээд боловсролтой”, 11 хувийг “Бүрэн бус дунд боловсролтой”, 7.0 хувийг “Тусгай дунд боловсролтой”, 2.0 хувийг “Бага боловсролтой” иргэд эзэлж байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэрэгт төрийн гурван алба хаагч, 13 сурагч, 28 оюутан, нэг хоригдол, хоёр тэнэмэл иргэн, сургууль завсардсан хоёр хүүхэд холбогдон шаллагдаж,

яллагдагчаар татагдсан байна. Нийт яллагдагчдын 54.0 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 21.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 15.0 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч нар байна.


Одоогийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэгт нийт 171 хоригдол ял эдэлж байна. Хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа нийт этгээдийн 10.5 хувь нь эмэгтэй, 89.5 хувь нь эрэгтэй, 47.5 хувь нь давтан гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байна.

Харин сүүлийн найман жилийн хугацаанд гадаадын 12 улсаас Монгол Улсын хилээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар нэвтрүүлсэн 76 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 37.9 хувийг газраар, 12.1 хувийг агаараар, үлдсэн 50 хувийг шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан үйлдсэн. Эдгээрийн 75 хувийг БНТУ, БНСУ, АНУ, ОХУ, БНХАУ-аас оруулж ирсэн байна. Гэмт этгээдүүдийн зүгээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг карго, шуудан илгээмж ашиглах, ачаа тээш, биедээ нууж улсын хилээр нэвтрүүлэх, худалдан борлуулахдаа бүлэг зохион байгуулалтад орж тодорхой байршилд бодисыг нуух, гэмт хэргийн цахим сүлжээ, бусдын данс ашиглах, ойрын хүрээллийн хэрэглэгч, донтогч нарт гараас гарт дамжуулах зэрэг аргаар үйлджээ.

Хар тамхитай тэмцэх газрын дүн шинжилгээгээр Монгол Улсын 49 иргэн гадаад улсад ял эдэлж байгаагаас Хятадад 34, Солонгост 7, Туркт 5, Германд 2, Японд 1 хүн, түүнчлэн Вьетнамд 4, Малайзад 2 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байна (Хар тамхитай тэмцэх газар, 2025, р. 11).

Улсын хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн 5.1.3-т заасан мансуурсан гэх үндэслэлээр 2023-2024, 2025 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 631 зөрчлийн хэрэгт 629 хүнд зөрчлийн хэрэг үүсгэж, шүүхийн шийтгэврээр баривчилсан 454, шүүхийн шийтгэврээр торгосон 147 хүн, сургалтад хамруулсан /насанд хүрээгүй хүн/ 28 хүн бүртгэлтэй байна.

График 4. Зөрчлийн хэрэг ба холбогдогч



Мөн Хар тамхитай тэмцэх газрын хийсэн судалгаагаар сүүлийн хоёр жилийн хугацаанд улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж нас барсан 21 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж нас барсан хүн

Бодисын төрөл	2023	2024	2025.06 сар	Нийт
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой нас баралт	2	5	3	10
Энгийн эмийг мансуурах зорилгоор урвуулан хэрэглэж нас барсан	-	3	2	5
Ахуйн хэрэглээний газ хэрэглэж нас барсан	1	2	3	6
Нийт	3	10	8	21

Дөрөв. Олон улсын нөхцөл байдал

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны 2025 оны тайланд дурдсанаар Зүүн болон Зүүн Өмнөд Азид 2024 онд 236 тонн метамфетамин хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад 24 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд энэ бүсэд Монгол Улсыг хамааруулсан байна (НҮБ-ын Хар тамхи мансууралтай тэмцэх газар, 2025).

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын Эрүүгийн бодлогоор героин, амфетамин, морфин, олсны ургамал /каннабис/, кокаин улсын хяналтад байвал зохих, хүнд донтох зуршил бий болгох магадлалтай мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хилээр нэвтрүүлсэн, худалдсан, тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн тохиолдолд хэмжээнээс үл хамааран гэмт хэрэгт тооцож ял оногдуулдаг байна. Үүнд:

- Хууль бусаар олж авсан (зорилго заагаагүй), хилээр нэвтрүүлсэн, худалдсан, тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн, тариалсан, устгахыг эсэргүүцсэн;
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэг, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагаанд оролцсон, гэмт үйлдэлдээ галт зэвсэг хэрэглэх, хууль сахиулах ажиллагааг эсэргүүцэн тэмцэлдэх зэрэг хууль бус үйлдэл гаргасан;
- Гэмт үйлдэлдээ насанд хүрээгүй хүнийг ашиглах, турхирах, гэмт этгээдийг хаацайлж, мансууруулах бодис эсхүл гэмт хэргээс олж авсан эд зүйлсийг нуун далдалсан, шилжүүлэн зөөсөн, нуун дарагдуулсан;
- Цууны исэл, эфир, хлороформ болон бусад мансууруулах бодис үйлдвэрлэхэд ашиглагдах түүхий эд, дагалдах бодисыг хилээр нэвтрүүлсэн, эсхүл хууль, тогтоомж зөрчиж улсын нутаг дэвсгэрт дээрх зүйлсийг хууль бусаар

наймаалах, мансууруулах бодис үйлдвэрлэж байгааг мэдсээр байж дээрх зүйлсээр хангасан;

- Мансууруулах бодисын эх ургамлууд болон үрслүүрийг тарих, бодис татах, тарих газар, орон байраар хангах;
- Хяналтад байвал зохих мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг албан тушаалаа урвуулан ашиглах замаар завшсан зэрэг үйлдэл нь гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд хамаардаг.

Амфетамин, метамфетамин, героин зэрэг хүчтэй үйлчилгээтэй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын чанар, хэмжээнээс болон хүүхэд, өсвөр насны хүмүүсийг энэ хэрэгт уруу татсан, ашигласан, татан оролцуулсан тохиолдолд хүндрүүлэн үзэж цаазаар авах хүртэл ял оногдуулах эрх зүйн зохицуулалттай байна. Энэ нь хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалсан, урьдчилан сэргийлэх агуулгатай эрүүгийн эрх зүйн бодлогын давуу тал юм. Эрүүгийн хариуцлага хүлээх субъект нь хувь хүнээс гадна, хуулийн этгээд байхаар заасан байдаг.

БНХАУ-д 2024 оны байдлаар 2.5 сая орчим мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч байдаг гэсэн судалгаа гарчээ. НАХЯ-ны харьяанд “Мансууруулах бодисын хяналтын товчоо” бие даасан газрын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд мансууруулах бодистой холбоотой 165 мянган гэмт хэрэг бүртгэгдэж, 102.5 тонн бодис хураагдсан байна (БНХАУ-ын мансууруулах бодисын нөхцөл байдлын тайлан, 2023).

Тус улсад 2007 онд батлагдсан Хар тамхины эсрэг хуулийн дагуу урьдчилан сэргийлэх, хууль сахиулах, донтогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц бодлогыг хэрэгжүүлдэг. Хар тамхитай тэмцэх алба нь Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас гадна Мансууруулах бодистой тэмцэх үндэсний хороо, Эрүүл мэндийн яам, Хүнс, эмийн захиргаанд ажлаа тайлагнадаг.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаны үндсэн зорилго нь мансууруулах бодисын хор уршгийн талаарх мэдлэгийг олон нийтэд түгээх, урьдчилан сэргийлэх, тухайлбал сургууль, ажлын байр, олон нийтийг хамарсан боловсролын кампанит ажил, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, уралдаан тэмцээн, ёс суртахууны мессежийг ашиглан хар тамхийг үл тэвчих бодлогыг түлхүү хэрэгжүүлж байна. Түүнчлэн сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлэг, үйлчилгээ, нөхөн сэргээх чиглэлийн бодлогыг хамтад нь хэрэгжүүлдэг. Мөн алба нь дотоод нэгжүүд буюу Тамгын газар, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Судалгааны алба, Хяналт шалгалт, аудитын товчоо, Хүний нөөц, сургалтын товчоо, Мэдээлэл сурталчилгааны товчоо, Хууль зүйн товчоо, Намын хороодоос бүрдэнэ. Чиг үүргийн нэгжүүдэд нэгдүгээр газар буюу үндэстэн дамнасан хар тамхитай тэмцэх товчоо, түүний харьяа тагнуул, мөрдөн шалгах хэлтсүүд, мансууруулах бодистой холбоотой дотоодын гэмт хэрэгтэй тэмцэх товчоо, донтолтоос сэргийлэх, эмчилгээний алба, шүүхийн шинжилгээний хүрээлэн, лабораториудаас бүрдэнэ.

Оросын Холбооны Улс

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр тус улсад анх 2003 онд Холбооны хар тамхитай тэмцэх хороог 40000 хүний орон тоотой Засгийн газрын бие даасан агентлаг болгон байгуулсан. Тус улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүд нь хүүхэд, өсвөр насныхныг ийм хэрэгт оролцуулах, ашиглах, эсвэл өөрсдөө гардан гүйцэтгэх, зохион байгуулах хэлбэрээр үйлдэгдэж байна. Судлаачдын (Т.Г.Газизова, 2016) үзэж байгаагаар сүүлийн үед гэмт этгээдүүд хариуцлагаас зайлсхийхийн тулд ихэвчлэн насанд хүрээгүй хүүхдүүдийг татан оролцуулж байгаа аж. Тухайлбал: ерөнхий боловсролын болон их дээд сургууль, оюутны дотуур байранд тэдний хүрээллээр дамжуулан чөлөөтэй борлуулалт хийлгэх, улмаар хэрэглэх сэдэл, нөхцөл байдал бүрдүүлдэг гэж үзжээ.

Тус улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дараах үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулдаг байна. Үүнд:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис буюу тэдгээртэй адилтгах зүйлийг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах буюу илгээх, ашиглан шамшигдуулах, эсхүл авахаар далайлган сүрдүүлэх, хэрэглэхэд бусдыг хатгах;
- Тариалахыг хориглосон ургамлыг тарих буюу ургуулах, түүнчлэн олс, намуу цэцэг буюу мансууруулах бодис агуулсан бусад ургамлыг тариалах;
- Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх байр байгуулсан, тэтгэх;
- Уг бодисыг хууль бусаар олгох, жор буюу олж авах эрх олгосон бусад баримт бичгийг хуурамчаар үйлдэх;
- Тусгай хяналтад байвал зохих бусад бодис үйлдвэрлэх ба бэлтгэхэд ашиглах адилтгал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гаалийн хяналт шалгалтаас нуун дарагдуулж, эсхүл баримт бичиг буюу гаалийн адилтгалын хэрэгсэл ашиглан хууран мэхэлж, эсхүл мэдүүлэхгүй буюу зохиомлоор мэдүүлж, улсын хилээр нэвтрүүлэх, түүнд албан тушаалын байдлыг ашиглах;
- Уг бодистой адилтгах зүйлийг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар үлэмж хэмжээгээр олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, бэлтгэсэн, дахин боловсруулах;
- Уг бодисыг бэлтгэхэд ашиглагдах багаж хэрэгсэл ба тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, дахин боловсруулах, хадгалах, бүртгэх, борлуулах, худалдах, хуваарилах, тээвэрлэх, илгээх, олж авах, ашиглах, гаргах, оруулах, эсхүл устгах журам зөрчсөн, түүнчлэн тэдгээрийг үйлдвэрлэхэд ашиглагдах ургамлыг тариалах журмыг түүнийг мөрдөх, мөрдүүлэх үүрэг бүхий этгээд зөрчсөнөөс тэдгээр нь алдагдсан, эсвэл шунахай сэдэлтээр үйлдсэн, хүний эрүүл мэндэд гэм хор буюу өөр хүнд хор уршиг болгоомжгүй учруулах зэргийг гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан байна.

Гэмт хэрэг үйлдсэн, 16 насанд хүрээгүй хүүхдэд зургаа, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн 18 насанд хүрээгүй хүүхдэд арван жил хүртэл хугацаатай хорих ял ногдуулж, хүмүүжүүлэх ангид ялыг нь эдлүүлнэ. Тэдгээрт хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл түүнд ял ногдуулах ба ялаас чөлөөлж, боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгаж болох хуулийн зохицуулалттай байна.

Холбооны Хар тамхины хяналтын албыг тус улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2003 оны гуравдугаар сард анх байгуулсан. Тус байгууллага нь төвлөрсөн хяналтаар хар тамхины хууль бус наймаа, зүй бус хэрэглээтэй тэмцэх, хар тамхитай тэмцэх төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, холбооны бусад болон олон улсын байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын хууль тогтоомжийг сахиулах бусад чиг үүрэгтэй юм.

Олон улсын өргөн хүрээтэй хамтын ажиллагаа явуулах чиглэлээр НҮБ-ын Хар тамхитай тэмцэх алба, Интерполтой хил дамнасан хамтын ажиллагаа, ялангуяа Төв Ази болон Афганистанаас героин худалдаалах “Хойд маршрут”-ыг хяналтад авах ажиллагаанд идэвхтэй оролцдог. Тодруулбал: стратегийн тагнуул, нууц ажиллагаа, хар тамхи хураах, түгээх сүлжээг илрүүлж устгах, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулдаг. Үндсэн бүтцэд Бодлого зохицуулалтын газар, Хяналт, тандалтын газар, Шуурхай удирдлагын газар, Хар тамхи хил нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хар тамхины хууль бус үйл ажиллагаатай тэмцэх газар, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх газар, Олон улсын хамтын ажиллагааны газар, Мөрдөн шалгах хэлтэс, Хүүхдийн хэлтэс, Гүйцэтгэх ажлын газар, Тусгай газар, Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Сэтгэцийн эрүүл мэндийн төв хамаардаг.

Хар тамхитай тэмцэх ерөнхий газраас гадна тус улсын Холбооны аюулгүй байдлын алба нь хар тамхитай холбоотой үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, сөрөг тагнуул, терроризмтой холбоотой хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг. Энэ нь тагнуулын байгууллага терроризмыг санхүүжүүлэх, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хар тамхины хэргийг харьяалан шалгаж байгаа Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай ижил байна.

Түүнчлэн ОХУ-д Хар тамхины эсрэг улсын хороог 2017 онд байгуулсан бөгөөд энэ нь бодлогын зохицуулалтын байгууллага юм. ЗХЖШ-ын сайдаар ахлуулсан түүнд янз бүрийн яамд, бүс нутгийн эрх баригчид, нийгмийн байгууллагуудын төлөөлөл багтдаг. Үндсэн чиг үүрэг нь үндэсний эмийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, эмийн чиг хандлагыг хянах, хар тамхитай тэмцэх чиглэлээр бүс нутаг, холбооны үйл ажиллагааг зохицуулах явдал юм.

Бүгд Найрамдах Турк Улс

Туркийн иргэний үндэсний цагдаа нь Дотоод хэргийн яаманд харьяалагддаг бөгөөд хот суурин газарт хууль сахиулах үүрэгтэй. Үндсэн чиг үүрэг нь хар тамхины

хууль бус наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх өргөн хүрээтэй үүрэг хариуцлагыг хамарна.

Орон нутгийн түвшинд хар тамхитай тэмцэх чиг үүргийг Жандармерын ерөнхий командлал хариуцаж, хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах, тэр дундаа зарим мужид хар тамхины эсрэг ажиллагаа, терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулдаг. Хар тамхитай тэмцэх газар нь хар тамхины эсрэг үндэсний стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэглээний чиг хандлагыг хянах, шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Туркийн Үндэсний цагдаагийн газрын хууль бус наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх болон хар тамхитай тэмцэх газрын мэргэжил, арга зүйн удирдлагын бүтцэд Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын академийг байгуулан сургалт, соён гэгээрүүлэх, урьдчилан чиг үүргийг гүйцэтгүүлж байна. Хар тамхитай тэмцэх газар нь Удирдлагын төв, Хяналтын зөвлөл, Хуулийн хэлтэс, Хүний нөөцийн хэлтэс, Сургалтын хэлтэс, Тусгай ажиллагааны хэлтэс, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтэс, Аудитын тасаг, Хар тамхи улсын хилээр нэвтрүүлэхтэй тэмцэх хэлтэс, Хууль бус наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Орон нутгийн 81 муж дахь хар тамхитай тэмцэх хэсгүүдээс бүрдэж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Үндэсний цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх албыг 2002 онд мөрдөн шалгах, хар тамхины хууль бус эргэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй байгуулсан байна. Тус алба нь Өмнөд Солонгосын нутаг дэвсгэрт хар тамхи түгээх, хууль бусаар хил нэвтрүүлэх, зүй бусаар ашиглах гэмт хэргийг мөрдөн шалгах, тэмцэх, хяналт тавих үүргийг өдөр тутам гүйцэтгэж, Мансууруулах бодис, түүхий эдийн эргэлтэд хяналт тавих, Холбогдох гэмт хэргийг мөрдөн шалгах, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх гэсэн гурван чиглэлээр мастер төлөвлөгөө хэрэгжүүлэн ажилладаг. Бүтцийн нэгжийн хувьд бодлогын хэлтэс, сургалт, хүний нөөцийн алба, дүн шинжилгээ, тандалт судалгааны нэгж, мониторинг аудит болон мөрдөн шалгах чиглэлийн хэлтсүүд ажиллаж байна.

Тав. Хар тамхийг хэрхэн устгаж буй гадаад улсын туршлага

НҮБ-ын Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх албанаас “Хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэхэд ашиглагддаг химийн бодисуудыг аюулгүй хадгалах, устгах зааварчилгаа”-г 2006 онд батлан мөрдөж, 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг журамд дурдсанаар дараах таван төрлийн арга зүйгээр хар тамхи, мансууруулах бодисыг устгадаг. Үүнд: (UNODC, 2009)

- Шатаах арга (Incineration) нь хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисыг 1000-1200 хэмийн өндөр температурт зориулалтын, галд тэсвэртэй доторлогоотой шатаах зууханд шатаах замаар молекул бүтцийг нь бүрэн задлан устгадаг

хамгийн найдвартай арга бөгөөд шатаалтын явцад ялгарах хорт утааг тусгай шүүлтүүр, угаагч төхөөрөмжөөр цэвэршүүлэн гадагшлуулдаг ба энэ үйл ажиллагаа нь прокурор, цагдаа, байгаль орчны хяналтын байгууллагын төлөөллийн хяналт дор албан ёсоор явагддаг.

- Химийн саармагжуулалт (Neutralization/Degradation) нь сэтгэцэд нөлөөт бодисыг хүчил, суурь, исэлдүүлэгч бодисоор задалж хоргүй, саармаг нэгдэл болгон хувиргах арга бөгөөд энэ үйлдэл нь хаалттай, хяналттай орчинд хийгдэх ёстой. Биологийн болон химийн эрсдэлтэй байдаг учир нээлттэй орчинд хэрэглэхийг хориглодог.
- Шингээх ба бэхжүүлэх арга (Absorption and Solidification) нь устгах шаардлагатай бодисыг цемент, шавар, үнс, модны үртэс зэрэг шингээгч материалд шингээж дахин ашиглах боломжгүй, тогтворжсон хатуу төлөвт оруулсны дараа зөвшөөрөгдсөн, баталгаажсан хогийн цэгт аюулгүйгээр булшилж устгах бөгөөд энэ арга нь өндөр хүчин чадал бүхий шатаах төхөөрөмжгүй улс орнуудад тохиромжтой шийдэлд тооцогддог.
- Хөрс, усыг хамгаалан булшлах (Secure Landfilling) арга нь шатаах эсвэл химийн саармагжуулалтад тохиромжгүй бодисын үлдэгдлийг ус, хөрс нэвчихгүй хамгаалалттай тусгай хяналттай бүсэд булшилж устгадаг бөгөөд булшлах бодис нь цаашид химийн урвалд орохгүй, байгаль орчинд хорт нөлөө үзүүлэхгүй болсон байх шаардлагатай.
- Дахин боловсруулалт, хоргүй болгох арга (Where applicable) нь тодорхой төрлийн урвалж болон химийн бодисын бүтэц, аюулгүй байдлыг бүрэн мэддэг тохиолдолд хэрэглэгддэг бөгөөд эдгээр бодисыг сэргээн ашиглах эсвэл энгийн хог болгон хувиргах боломжийг ашигладаг ба ийм ажиллагаа нь зөвхөн хууль эрх зүйн зөвшөөрөл бүхий, шаардлага хангасан лаборатори, технологийн орчинд хэрэгжих боломжтой байдаг.

Олон улсад хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг устахдаа дараах туршлагыг ашиглаж байна. Үүнд:

Хүснэгт 2. Судалгааны үр дүн

Улс	Туршлага	
	Ургамал	Бодис
Америк	DEA-(Drug Enforcement Administration буюу АНУ-ын Мансууруулах бодистой тэмцэх газар)-аас 2022 онд 10660.6 га талбайд каннабис, 5494.7 га талбайд опиумыг тус тус устгасан (Affairs United States Department of State Bureau for International Narcotics and Law Enforcement, 2024).	DEA-ээс 2023 онд 77 сая гаруй фентанил шахмал, 5.4 сая кг нунтаг бодис, (Агентлагийн түүхэн дэх хамгийн их хэмжээний фентанилыг хураан авчээ, 2025) 181 тонн гаруй фентинал шахмал, 12.2 сая кг нунтаг бодисыг тус тус устгасан (Affairs United States Department of State Bureau for International Narcotics and Law Enforcement, 2024).

Устгадаг туршлага	АНУ байгальд зэрлэгээр ургадаг мансууруулах үйлчилгээтэй ургамлыг тусгай эргүүл, агаарын тандалт, механик түүвэр, химийн бодис ашиглан гар аргаар буюу техник хэрэгсэлтэй хослуулан устгах арга зүйгээр устгадаг. Мөн зэрлэгээр ургадаг мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгахдаа түүх, зулгаах, хураах аргаар цуглуулж, дараа нь тусгай зөвшөөрөлтэй байгууламжид шатаах incineration аргыг ашиглан устгадаг. Incineration-Өндөр температурт шатаах замаар хог хаягдал, хорт бодис, мансууруулах бодисыг бүрэн устгах үйл явц юм.	АНУ химийн аргаар гаргаж авсан мансууруулах бодисыг устгахдаа өндөр температурт шатаах, химийн саармагжуулалт, хяналттай устгалын тогтолцоог хослуулсан нэгдсэн арга зүйг хэрэглэдэг. Тухайлбал: фентанил, метамфетамин зэрэг өндөр хор нөлөөтэй синтетик бодисыг Байгаль орчны агентлаг EPA (Environmental Protection Agency буюу Америкийн Байгаль Орчныг Хамгаалах Агентлаг) болон Мансууруулах бодистой тэмцэх газар (DEA)-аас зөвшөөрсөн тусгай зууханд 1200 хэмээс дээш температурт бүрэн шатааж, дахин хэрэглэх боломжгүй байдлаар устгадаг.
Мексик	2022 онд 9108 га талбайд, 2024 онд 12800 га талбайд (Affairs United States Department of State Bureau for International Narcotics and Law Enforcement, 2024) каннабисыг тус тус устгасан.	2023 онд 367.2 мянган тонн метафетамин, 604.1 мянган тонн химийн аргаар гаргаж авсан мансууруулах бодисыг тус тус устгасан (Мексикийн Тэнгисийн цэргийн хүчин 2023 онд хар тамхины хууль бусаар хураан авсан рекорд жилтэй байжээ, 2024).
Устгадаг туршлага	Мексикэд байгальд зэрлэг байдлаар ургасан мансууруулах үйлчилгээтэй ургамлыг (каннабис, опиумын намуу) илрүүлэн устгахдаа хосолмол арга зүй ашигладаг. Тухайлбал: цэргийн болон цагдаагийн тусгай ангиуд нисэх онгоц, нисдэг тэрэг ашиглан паракват зэрэг химийн бодисоор агаар шүрших (aerial spraying) аргаар ургамлыг хуурайшуулах, эсвэл үхүүлсний дараа гар аргаар түүж, газар дээр нь овоолж шатаах аргаар бүрэн устгал хийдэг. Энэ үйл ажиллагаа нь өндөр хяналттайгаар, ил тод байдлаар явагддаг бөгөөд олон нийтийн оролцоотойгоор хэрэгждэг. Ийнхүү химийн болон физик устгалын аргыг уялдуулан хэрэглэснээр зэрлэг байдлаар ургасан хар тамхины түүхий эдийн хангамжийг бууруулах, хууль бус үйлдвэрлэлийг эх үүсвэр дээр нь таслан зогсоох зорилгоор хэрэгждэг тогтмол ажиллагаа болдог.	Мексик нь химийн аргаар гаргаж авсан мансууруулах бодисыг устгахдаа цэргийн алба хаагчид хууль бус лабораторийг илрүүлэн устгасны дараа хаягдал химийн бодис, тоног төхөөрөмжийг газрын дээр нь шатаах арга хэрэглэдэг.
Турк	2023 онд 37447 га талбайд, (Олон улсын хар тамхины хяналтын зөвлөл, 2024) 2025 онд 700 га талбайд марихуаныг тус тус устгасан (Турк 30 мянган марихуан ургамлыг устгасан, 2025).	Мэдээлэл байхгүй.

Устгадаг туршлага	Турк нь байгальд зэрлэгээр ургасан мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгахдаа эхлээд нисэх онгоц, дрон ашиглан илрүүлж, химийн бодисоор шүршин устгасны дараа, гар аргаар түүж газар дээр нь овоолж шатаах хосолсон арга хэрэглэдэг. Үүний тод жишээ нь 2024 онд Лице хотод 20 тонн каннабисыг шатааж устгасан явдал юм.	Турк нь химийн аргаар гаргаж авсан мансууруулах бодисыг устгахдаа тусгай хамгаалалттай газар байрлах өндөр температурт шатаах зориулалтын зуух ашигладаг бөгөөд энэ аргаар тухайн бодисыг бүрэн устгаж, дахин хэрэглэх боломжгүй болгодог.
Колумб	2023 онд 20325 га талбайд кока ургамлыг устгасан (cropmonitoring баримтууд, 2023).	Мэдээлэл байхгүй.
Устгадаг туршлага	Колумб нь мансууруулах ургамлыг устгахад ихэвчлэн гар аргаар түүж шатаах, мөн зарим тохиолдолд агаараас химийн бодис цацан хатаах аргыг хэрэглэдэг.	Колумб нь химийн гаралтай мансууруулах бодис (фентанил, метамфетамин, синтетик капсул зэрэг)-ыг хууль хяналтын байгууллагаас хураан авч, төвлөрсөн хяналттай нөхцөлд шатаах, өндөр температурт шатаах зууханд устгах, эсвэл тусгай технологийн аргаар устгах хэлбэрээр устгадаг.

Дүгнэлт

Монгол Улсад хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт болон түүнтэй холбоотой гэмт хэргүүд нь нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул учруулж, улам бүр түгэн дэлгэрсээр байна. Гэмт хэргийн тоо, төрөл нэмэгдэж, ялангуяа залуу үеийнхний дунд шинэ төрлийн синтетик бодисын хэрэглээ, туршилт нэмэгдэж байгаа нь онцгой анхаарал татаж байна. Энэ нь цахим орчны нөлөөлөл, мэдээлэл харилцааны хялбар байдал, мөн бодисын төрөлжилт зэрэгтэй холбоотой юм.

Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгах ажиллагаа нь олон улсын конвенц болон дотоодын хууль, журмаар зохицуулагддаг ч практик дээр хэрэгжилт нь хангалтгүй, зарим зохицуулалт нь хуучирсан, цаг үеэсээ хоцорсон байдал ажиглагдаж байна (ЦЕГ, 2025). Тухайлбал: Устгалын явцад мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, шийдвэрийг заавал үндэслэх тухай заалт нь байгууллагын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан хэрэгжих боломжгүй болжээ. Мөн журамд заасан тусгай комисс томилох, устгалын явцад мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулах зэрэг заалт нь бодит байдал дээр тогтмол мөрдөгдөхгүй байна. Одоогоор хууль бус эргэлтээс хураагдсан болон хүчинтэй хугацаа дууссан бодисын устгалыг ихэвчлэн тусгай зөвшөөрөлтэй компаниар, цагдаа болон эрүүл мэндийн байгууллагын хяналт дор хийж байгаа ч үйл явцыг нэгтгэсэн, ил тод протокол дутмаг байгаа нь уг ажиллагааны үр дүн, хариуцлагыг бууруулж болзошгүй юм. Харин гадаадын туршлагыг авч үзвэл, Америк, Мексик, Турк, Колумб зэрэг улсад мансууруулах бодис устгахдаа

өндөр температурт шатаах (1000–1200°C), химийн саармагжуулалт, гар аргаар түүж шатаах, агаараас химийн бодис цацах, шингээж бэхжүүлэх болон булшлах зэрэг олон аргыг ашиглаж, үйл явцыг маш хатуу хяналттай, ил тод байдлаар хэрэгжүүлдэг. НҮБ-ын Мансууруулах эмийн хяналтын алба (UNODC)-ны удирдамжид ч мансууруулах бодисыг устгахдаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй, бүрэн устгал хийхийг шаарддаг бөгөөд өндөр температурт шатаах, химийн саармагжуулалт зэрэг аргыг оновчтой хослуулан хэрэглэхийг зөвлөсөн байдаг.

Иймд Монгол Улс нь олон улсын шилдэг туршлага, зөвлөмжийг нэвтрүүлж, устгалын үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг сайжруулж, хяналтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна. Энэ нь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэй тэмцэх нийтлэг үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулах юм.

Эх сурвалжийн жагсаалт

Affairs United States Department of State Bureau for International Narcotics and Law Enforcement. (2024). *International Narcotics Control Strategy Report*. АНУ.

cropmonitoring баримтууд. (2023). *Колумбын судалгааны тайлан*. Колумб.

UNODC. (2009). *Guidelines for the Safe Handling and Disposal of Chemicals Used in the Illicit Manufacture of Drugs*. Австри.

Агентлагийн түүхэн дэх хамгийн их хэмжээний фентанилыг хураан авчээ. (2025 оны 9 8). https://www.chronline.com/stories/dea-seizes-greatest-amount-of-fentanyl-in-agency-history-in-2023%2c332931/?utm_. <https://www.chronline.com.-ээс> Гаргасан

БНХАУ-ын мансууруулах бодисын нөхцөл байдлын тайлан. (2023). *Мансууруулах бодисын 2023 оны нөхцөл байдлын тайлан*. БНХАУ.

Гадаад харилцааны яам. (2018). *Монгол Улсын Нэгдэн орсон олон улсын гэрээний эмхэтгэл*. Улаанбаатар хот: Төрийн эмхэтгэл.

Засгийн газрын 2003 оны 196 дүгээр тогтоол. (2003). *Засгийн газрын тогтоол*. Улаанбаатар: Төрийн эмхэтгэл.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. (2016). *Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал*. Улаанбаатар: Төрийн эмхэтгэл.

Мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 7.2.1. (2002). *Монгол Улсын хууль*. Улаанбаатар: төрийн эмхэтгэл.

Мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 7.2.2. (2002). *Монгол Улсын хууль*. Улаанбаатар: Төрийн эмхэтгэл.

Мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 7.2.3. (2002). *Монгол Улсын хууль*. Улаанбаатар: Төрийн эмхэтгэл.

Мексикийн Тэнгисийн цэргийн хүчин 2023 онд хар тамхины хууль бусаар хураан авсан рекорд жилтэй байжээ. (2024 оны 1 4). https://mexiconewsdaily.com/news/mexican-navy-had-record-year-of-illicit-drug-seizures-in-2023/?utm_source=. <https://mexiconewsdaily.com.-ээс> Гаргасан

НҮБ-ын Хар тамхи мансууралтай тэмцэх газар. (2025). *Ажлын тайлан*. АНУ-ын Нью-Йорк.

Олон улсын хар тамхины хяналтын зөвлөл. (2024). *Тайлан*. Австри.

Судалгааны тайлан. (2024). *Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх*. Улаанбаатар.

Газизова Т.Г. (2016). *Судалгаа*. ОХУ.

Турк Улс 30000 марихуан ургамлыг устгасан. (2025). *Тайлан*. Турк.

Хар тамхитай тэмцэх газар. (2025). *Дүн шинжилгээний тайлан*. Улаанбаатар хот.

Хууль зүйн үндэсний төв. (2023). *Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ*. Улаанбаатар.

Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мансууруулах сэтгэгцэд нөлөөт эмийг устгууллаа. (2022 оны 9 19). <https://mmra.gov.mn/?id=200617>. mmra.gov.mn.-ээс Гаргасан

ЦЕГ. (2025). *Дүн шинжилгээний тайлан*. Улаанбаатар: Хар тамхитай тэмцэх газар.

ЦЕГ. (2025). *Хар тамхитай тэмцэх газар*. Улаанбаатар: Дүн шинжилгээний тайлан.

Foreign and Domestic Experiences and Future Approaches in Combating Illicit Drug Trade

Delgersaikhan Tumurtogtokh

Master in Law, Senior researcher, delgersaikandisa@gmail.com

Strategy, Policy, Innovation and Development Department of
National Police Agency, Ulaanbaatar, Mongolia

Abstract

Drug trafficking is a serious threat to the world today, and it has a significant negative impact on public health, national security, and sustainable economic development of countries. This research article summarizes the accumulated experience and achievements of international and Mongolian efforts to combat drug trafficking, and aims to identify effective policy directions for the future.

The study analyzes the negative consequences of drug trafficking, as well as the legal framework and implementation issues to combat it. In particular, it presents a comparative study of the effectiveness of comprehensive measures such as prevention, suppression, treatment, and rehabilitation in international standards and the Mongolian situation. It also addresses the difficulties and challenges faced in combating crime, such as technological advances and the organized nature of crime. The main contribution of this article is to propose a comprehensive strategy and new directions for cooperation to combat drug trafficking, based on the results of the study.

Keywords: Drugs, Public health, Prevention, International cooperation, Border control.

Received: September 10, 2025 | Accepted: September 17, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025

<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.